



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 242

Мандалговь

┌ Хөрөнгө худалдах тухай ┐

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3.1.д, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 157'690'600 /нэг зуун тавин долоон сая зургаан зуун ерэн мянга зургаан зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 62'090'500 /жаран хоёр сая ерэн мянга таван зуу/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Хүн эмнэлэгийн барилгыг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 35'000'000 /гучин таван сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудг. а худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын дарга Ю.Дашдаваад даалгасугай.

ДАРГА

С.БУДЖАВ



0100502